



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 05 сарын 24 өдөр

Дугаар 06

Сүхбаатар сум

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны үйл ажиллагааны үр дүнгийн тухай

Сангийн Сайдын 2019 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны үйл ажиллагааны тайланг хорооны хурлаар хэлэлцээд ТОГТООХ нь:

Нэг. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан Санхүүгийн хяналт дотоод аудитын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г 4 бүлэг, 23 арга хэмжээтэйгээр боловсруулан, батлуулж, хэрэгжилтийг тайлагнахад бүрэн хэрэгжсэн 15, дутуу хэрэгжсэн 7, огт хэрэгжээгүй 1 дундаж үнэлгээ 87.6% хувьтай тайлагнагдсаныг Хяналт, шинжилгээ-үнэлгээ дотоод аудитын хэлтсээс хийсэн үнэлгээгээр 81.7 хувьтай дүгнэгдсэн тул 2023 оны үйл ажиллагааг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

Хоёр. Цаашид аудитын хорооны гишүүдээс тус албаны Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний үндсэн үйл ажиллагааны үр дүн, хяналт шалгалтын чанар, үр өгөөжийг нэмэгдүүлэхэд авах арга хэмжээнд санал зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, мэргэжил арга зүйгээр хангахад удирдлага болгон ажиллахыг Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга (Т.Одсүрэн)-д зөвшөөрсүгэй.

Хорооны дарга:  Н.Лхагвадорж
(Аймгийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга:  Т.Мөнхзул
(Ахлах дотоод аудитор)

Гишүүд:  Т.Одсүрэн
(Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга)

Ө.Сувдаа
(Аймгийн Засаг даргын
Тамгын газрын дарга)

4324009006



Х.Мөнхжаргал
(Санхүү төрийн сангийн хэлтсийн
даргын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч)



А.Дашбат
(Иргэний төлөөлөл)